

# Бүлэг 1: Уран зохиолын хүүрнэмж


Ээлжит хичээлийн сэдэв №6: Хүүрнэсэн эхийн үйл явдал ба учир шалтгааны уялдаа

Ээлжит хичээлийн зорилго:

Хүүрнэсэн эхийн бүтэц, ба үйл явдлын учир шалтгааны холбоо хамаарлыг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних

Суурилах эх хэрэглэгдэхүүн:

- Богино үлгэр
- өгүүллэг



- Ном унших дуртай юу?
- Зарим үед номондоо орж, цааш яаж үргэлжлэх бол? Яаж төгсөх бол? гэж яарч догдолж байсан уу? Ярилцаарай.

# Дараах эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

## Эцгийн захиас


Эрт урьд цагт гурван хүүтэй нэгэн анчин байжээ. Тэрээр ан гөрөө хийж, аж төрөн суудаг байв.

Анчин насан өндөр, хүчин дорой болж, нэг өдөр утаа гартал татаж тавьдаг увдист шар нумаа их хүүдээ өгч, “Миний гурван хүү тулга хийх нэг нэг чулуу олж ир.” гэжээ. Гурван хүүгийнхээ авчирсан чулууг тулга болгон, гал түлж, тогоо тавиад, цай чанаж эхэлжээ. Дараа нь “Та гурав тус тусын авч ирсэн чулуугаа ав.” гэснийг ёсоор болгохуйд тогоо нь хөмөрч, цай нь асгарч, гал нь унтарчээ.

Тэгсний хойно “За, миний гурван хүү харав уу? Орчлон гэдэг тогооны ёроол адил бөөрөнхий. Иймээс тулгын гурван чулуу шиг бие биеэ харж, эвтэй явах хэрэгтэй. Хэрэв эвдрэлцэж муудвал энэ хөмөрсөн тогоо, асгарсан цай, унтарсан гал мэт болно.” хэмээн сургамжилжээ.

**Алхам 2:** Сэтгэл хөдлөл дээр тулгуурлан, үлгэрийн үйл явдлаас тохирохыг хоосон зайд нөхөж, үйл явдлын өгүүлэгдэхүүн бүтцийг тодорхойлоорой.

**Үйл явдал:** Зохиол эхнээсээ тодорхой дарааллаар өрнөн, өөр хоорондоо хөдөлгөөн харилцаанд орсон тогтолцоог үйл явдал гэнэ. Үйл явдал нь өгүүлбэрээр илэрнэ. Өгүүлбэрт хэдэн үйл үг байна, түүний тоогоор үйл явдал байна. Үйл явдал нь эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл гэсэн өгүүлэгдэхүүн бүтцийн дагуу үргэлжилж, уншигчийн сэтгэлийг хөдөлгөж, цааш унших сонирхлыг төрүүлдэг.



# Дасгал 1: Үйл явдлын учир шалтгааны холбоо хамаарлыг задлан шинжлээрэй.

## Алхам 1: Дараах шалтгааны асуултад хариулж бичээрэй.


**Учир шалтгаан:** Юм бүхэн, болж байгаа үйл явдал бүр ямар нэг шалтгааны улмаас үүсдэг. Эхний үйл явдал нь дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болно. Ингэж үйл явдлууд өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой болно.

Асуулт	Хариулт
• Анчин яагаад их хүүдээ увдист шар нумаа өгсөн бэ?	----- -----
• Анчин яах гэж гурван хүүгээрээ тулга хийх чулуу авчруулсан бэ?	----- -----
• Юунаас болж тогоо хөмөрч, цай асгарч, гал унтарсан бэ?	----- -----
• Юуны учир тулгын гурван чулуу шиг бие биеэ харж, эвтэй яв” гэж сургамжилсан бэ?	----- -----

**Алхам 3:** Үйл явдлын учир шалтгааны хамаарлыг тодорхойлохдоо сумаар холбож гүйцээнэ үү.

**Түлхүүр үг гэж юу вэ?**

Эхэд олон давтагдаж орсон болон эхийн утга санааг гаргахад чухал үүрэгтэй үгсийг хэлнэ.



**Алхам 4:** Үйл явдлын учир шалтгааны холбоо хамаарлаар ямар санаа илэрхийлснийг тайлбарлаарай.

- Тулгын гурван чулуугаар юуг бэлгэдсэн бэ?

.....

- Тогоо, цай, галаар юуг төлөөлүүлж ойлгуулсан бэ?

- .....

- Анчин өвгөний чин хүсэл, захиасны гол санаа юу байсан бэ?

- .....

- .....

## *Алхам 5:Хичээлээ нэгтгэн дүгнэхдээ дараах асуултад хариулаарай.*

- Учир шалтгааны асуултуудыг нэрлэн бичээрэй.
- “Уран зохиолын хүүрнэсэн эх нь ямар ямар үндсэн шинжүүдтэй юм байна” гэж ойлгосон бэ? Нөхөж бичээрэй.

1. Уран зохиолын хүүрнэмж эх нь ..... Тэр үйл явдлууд нь эхийн агуулгын бүтцийн хүрээнд өөр хоорондоо ..... хамаарлаар холбогдож, тодорхой, чухал санааг гаргах ба эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл гэсэн дарааллаар өрнөн, ..... татаж, цааш унших хүсэл, тэмүүллийг бий болгодог.